

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ЭРДЭНЭБААТАР ТАНАА

2020.02.27 № 06/624
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Богд хааны ордон музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Богд хааны ордон музейн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Богд хааны ордон музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн балансын данс болон зардлын дансны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу бүртгэх 2 зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд хааны ордон музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “СМД аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Гэндэнпэлжээ ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Богд хааны ордон музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Богд хааны ордон музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь олон нийтэд нээлттэй, байнгын тасралтгүй үйл ажиллагаатай, халхын найман Богд, Монгол буддизм, ХХ зууны эхэн үеийн үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхтэй холбоотой гэрч болох соёлын өвийг цуглуулах, хадгалан хамгаалах, судлан шинжилж, сурталчлах, дэлгэн үзүүлэх, сэргээн засварлах, бүртгэн баримтжуулах төв байж, соёлын биет болон биет бус өвөөр дамжуулж нийгэмд нөлөөлөх байгууллага байхад оршино.

Богд хааны ордон музейн улсын бүртгэлийн гэрчилгээнд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг музей, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”;
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол;
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус музейн одоо мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Богд хааны ордон музей нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Гөү-Окей” ХХК-ийн “Explore” программ хангамж ашигладаг байна.

Богд хааны ордон музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Богд хааны ордон музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 523,553.3 мянган төгрөгөөс тооцон 10,471.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойг тохиолдуулан эрдэм, шинжилгээний ажил, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор, гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд эрсдэл бага тул материаллаг байдлыг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 840,166.1 мянган төгрөгийн 2 хувь буюу 16,803.3 мянган төгрөгөөр тогтоов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Богд хааны ордон музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 655.7 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, данснуудад материаллаг өөрчлөлт гарсан.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6.7	-	-6.7
Авлага	52,080.2	27,935.2	-24,145.0
Урьдчилгаа	68,884.8	101,358.2	32,473.4
Бараа материал	159,021.4	258,081.0	99,059.6
Үндсэн хөрөнгө	17,642,745.4	17,534,708.4	-108,037.0
Нийт хөрөнгө	17,922,738.5	17,922,082.8	-655.7
Өр төлбөр	4,988.3	4,193.4	-794.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	17,917,750.2	17,917,889.3	139.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,922,738.5	17,922,082.8	-655.7

Авлага дансны үлдэгдэл 24,145.0 мянган төгрөгөөр буурсан нь урд оны авлага хаагдсанаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд, он удаан жил болсон барагдах боломжгүй, эрсдэлтэй авлага байхгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 99,059.6 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос худалдан авалт хийснээс шалтгаалжээ. 2019 оны 12 сард нийт 135,587.3 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалд бүртгэсэн байсан ба нэр төрлөөр нь харвал бусад хангамжийн материалд “8 дугаар Богд Жавзандамба хутагтыг Төвдөөс Монгол оронд залж авчирсан тухай” ном 250 ш, “Сарьдгийн хийдийн каталог” 50 ш, “Чин Улс хийгээд Жавзандамба хутагт” 500ш гэх мэт номын эх бэлтгэл, хэвлэлд 27,259.0 мянган төгрөг, Хаан хатны зоосны загвар 2 ш 9,000.0 төгрөг, “Богд хаант Монгол улсад холбогдох баримт боть 1,2,3,4” номын эх бэлтгэлд 7,000.0 төгрөгөөр худалдаж авсан. Мөн цэвэрлэгээний материал, гэрэл, тэмдэглэгээ гэх мэт аж ахуйн

материал нөөц үүсгэсэн байв. Тайлбар авахад 4 сараас зуны хуваарьт шилжсэнээр цэвэрлэгээ үйлчилгээг өдөр бүр тогтмол хийдэг учраас цэвэрлэгээний материал ихээр нөөцөлсөн. Мөн жуулчид их ирдэг тул, тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор, гэрэл чимэглэл зэргийн нөөцийг тодорхой хэмжээнд нөөцөлдөг. Дээрх ном, зоосны эх бэлтгэл зэргийг хийлгэсэн нь зарж борлуулах барааны нэр төрлөө нэмэгдүүлж, байгууллагын өөрийн үйл ажиллагаанаас олох орлогоо нэмэгдүүлэх зорилготой гэв.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 25,309.0 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд 40,906.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, мөн ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах А-1/3612 тоот зөвшөөрлөөр 15,597.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,686.0 мянган төгрөг нь ажилчидтай холбоотой өглөг, 1507.4 мянган төгрөг нь байгууллагад өгөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,917,889.3 мянган төгрөг болж тайлант үеийн үр дүн 139.1 мянган төгрөгөөр өссөн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Богд хааны ордон музей орлого төвлөрүүлэхээр батлагдаагүй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл урлагийн хөтөлбөрт зориулан 448,867.7 мянган төгрөгийг урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд 448,867.7 мянган төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 426,590.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 426,597.7 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байна. Энэ нь ХХОАТ-ын өглөгтэй, 1 ажилтан хүүхдээ асрах эхийн чөлөө авсан, тог бага зарцуулдаг, гэрэл, цахилгааны үүсгүүрийг ашигласнаар байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 10,132.2 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Америкийн нэгдсэн улсын Төрийн Департаментын гадаад төсөл хөтөлбөрөөс хандив тусламжаар 2018 онд орсон, зарцуулагдаагүй төсөвт төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн 38,834.8 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 10,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 371,475.1 мянга, нийт 420,309.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 409,439.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 3,000.0 мянган төгрөг, нийт 412,439.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7,870.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэлд 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 7,889.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Богд хааны ордон музей нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Богд хааны ордон музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 7,889.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 16,803.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Богд хааны ордон музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нийт 3,134.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь аудитын оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Улирлын чанартай ажилладаг компаниудтай хамгийн сүүлд гүйлгээ хийх бүрд тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах, түүнчлэн авлагыг бууруулах талаар арга хэмжээ авах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна. Хойшид хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон 37,500.0 мянган төгрөгөөс, 3,750.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаад, 4,754.9 мянган төгрөгийн НДШ тооцоогүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг зөрчиж байна.

3.2.2. Эрсдэл:

Нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтаар акт, торгууль тавигдах эрсдэлтэй.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна. Хойшид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>279,993,114.41</u>	<u>387,374,360.33</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,734.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	6,734.00	-
31110	Төгрөг	6,734.00	-
33	АВЛАГА	52,080,166.08	27,935,176.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	60,200.08	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,614,600.00	12,951,400.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	39,097,916.00	1,507,225.00
335	Бусад авлага	10,307,450.00	13,476,551.00
3351	Байгууллагаас авах авлага	10,307,450.00	13,476,551.00
34	УРЬДЧИЛГАА	68,884,800.00	101,358,200.00
34600	Урьдчилж гарсан зардал	68,884,800.00	101,358,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	159,021,414.33	258,080,984.33
351	Түүхий эд материал	139,800.00	140,700.00
35130	Эм боох материал	139,800.00	140,700.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	12,564,000.00
354	Хангамжийн материал	158,881,614.33	245,376,284.33
35410	Бичиг хэргийн материал	4,588,122.00	9,420,706.00
35420	Аж ахуйн материал	60,963,722.33	85,699,033.33
35430	Сэлбэг хэрэгсэл	135,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	93,194,770.00	150,256,545.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,642,745,387.50</u>	<u>17,534,708,414.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,642,745,387.50	17,534,708,414.37
392	Биет хөрөнгө	16,529,167,187.62	16,422,494,214.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,028,891,829.34	2,028,891,829.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(488,781,258.980)	(572,189,348.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,077,777.78	20,077,777.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,731,481.20)	(20,077,777.780)
39205	Машин тоног төхөөрөмж -компьютер	311,030,434.75	337,747,098.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(174,136,973.97)	(216,789,624.110)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	204,207,069.38	200,244,624.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(156,161,803.470)	(158,736,709.12)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	14,785,597,927.99	14,785,597,927.99
39217	Ном	15,173,666.00	17,728,416.00
393	Биет бус хөрөнгө	1,113,578,199.88	1,112,214,199.84
39301	Програм хангамж	20,740,000.00	20,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,520,000.12)	(5,884,000.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,097,358,200.00	1,097,358,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>17,922,738,501.92</u>	<u>17,922,082,774.70</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,988,261.85</u>	<u>4,193,446.63</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,988,261.85	4,193,446.63
413	Өглөг	4,988,261.85	4,193,446.63
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	170,907.85	2,686,021.63
4136	Бусад өглөг	4,817,354.00	1,507,425.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,547,300.00	1,507,225.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	270,054.00	200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>17,917,750,240.07</u>	<u>17,917,889,328.07</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	17,917,750,240.07	17,917,889,328.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,382,378,312.91	4,382,378,312.91
51101	Өмч:- төрийн	4,382,378,312.91	4,382,378,312.91
512	Хуримтлагдсан үр дүн	55,514,727.97	55,653,815.98
51210	Өмнөх үеийн үр дүн	(40,264,914.45)	55,514,727.97
51220	Тайлант үеийн үр дүн	95,779,642.42	139,088.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,479,857,199.18	13,479,857,199.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>17,922,738,501.91</u>	<u>17,922,082,774.70</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	619,332,909.00	840,305,206.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	228,964,518.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	190,129,722.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	189,968,919.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	186,027,369.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,941,550.00	-
120009	Бусад орлого	160,803.00	-
122	Тусламжийн орлого	38,834,796.00	-
122002	Хандив тусламж /гадаад/	38,834,796.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	390,368,391.00	840,305,206.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	225,399,500.00	448,867,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	225,399,500.00	448,867,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	164,968,891.00	391,437,506.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,442,280.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	163,526,611.00	381,437,506.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	479,623,213.26	840,166,117.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	479,623,213.26	840,166,117.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,031,892.80	806,118,875.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,467,313.93	238,987,941.43
210101	Үндсэн цалин	137,320,121.78	238,987,941.43
210102	Нэмэгдэл	4,781,600.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,943,000.00	-
210104	Урамшуулал	13,422,592.15	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,280,139.45	30,606,038.27
210201	Тэтгэврийн даатгал	15,054,158.39	21,068,858.34
210202	Тэтгэмжийн даатгал	1,494,772.79	2,384,294.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,695,874.39	1,907,435.99
210204	Ажилгүйдлийн даатгал	373,693.20	476,859.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,661,640.68	4,768,589.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,958,931.96	38,599,002.38
210301	Гэрэл, цахилгаан	14,807,188.00	20,431,475.00
210302	Түлш, халаалт	16,840,634.00	16,863,421.56
210303	Цэвэр, бохир ус	1,311,109.96	1,304,105.82
2104	Хангамж, бараа материалын зардал	39,120,598.40	179,634,561.72
210401	Бичиг хэрэг	2,719,777.00	8,821,240.00
210402	Тээвэр, шатахуун	2,295,117.00	3,631,246.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,403,239.40	2,286,844.72
210404	Ном, хэвлэл	10,201,484.00	27,216,786.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,334,080.00	2,699,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,731,851.00	94,637,641.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	435,050.00	31,202,585.00
210408	Бараа материал акталсны зардал	-	9,139,139.00
2105	Нормативт зардал	21,950.00	361,225.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,950.00	109,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	252,125.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,014,160.00	7,895,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,980.00	1,835,000.00
210604	Урсгал засвар	1,012,180.00	6,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,210,000.00	10,034,200.00
210702	Дотоод албан томилолт	1,210,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	10,034,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,119,737.50	151,057,268.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,084,117.50	126,302,368.78
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,965,300.00	9,900,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	497,500.00
210807	Газрын төлбөр	2,982,320.00	7,116,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	5,740,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,839,061.55	148,943,638.13
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,839,061.55	148,943,638.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,591,320.46	34,047,242.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	3,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	3,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,091,320.46	30,147,242.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,091,300.46	22,276,763.83
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20.00	7,870,478.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	139,709,695.74	139,088.01
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,930,053.32	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	43,930,053.32	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(43,930,053.32)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	95,779,642.42	139,088.01

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	629,845,079.00	870,684,827.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,641,892.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	200,641,892.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,641,892.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,308,400.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	333,492.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,203,187.00	870,684,827.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	225,399,500.00	448,867,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	225,399,500.00	448,867,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	203,803,687.00	421,817,127.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	38,834,796.00	40,342,021.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,442,280.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	163,526,611.00	371,475,106.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	574,135,479.00	829,784,896.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,135,479.00	829,784,896.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	480,446,242.54	794,130,428.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,638,221.78	235,870,640.69
210101	Үндсэн цалин	137,320,121.78	154,700,610.69
210102	Нэмэгдэл	4,781,600.00	34,338,312.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,943,000.00	14,283,000.00
210104	Урамшуулал	13,593,500.00	32,548,718.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,446,029.00	30,549,189.88
210201	Тэтгэврийн даатгал	14,220,047.94	22,177,889.88
210202	Тэтгэмжийн даатгал	1,494,772.79	2,092,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,695,874.39	1,674,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	373,693.20	418,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,661,640.68	4,185,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,958,931.96	38,599,002.38
210301	Гэрэл, цахилгаан	14,807,188.00	20,431,475.00
210302	Түлш, халаалт	16,840,634.00	16,863,421.56
210303	Цэвэр, бохир ус	1,311,109.96	1,304,105.82
2104	Хангамж, бараа материалын зардал	31,365,296.40	70,319,123.72
210401	Бичиг хэрэг	5,210,060.00	7,539,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,024,117.00	3,031,246.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,838,239.40	2,586,844.72
210404	Ном, хэвлэл	11,940,000.00	37,846,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,334,080.00	2,699,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,018,800.00	16,615,503.00
2105	Нормативт зардал	1,844,300.00	10,884,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,844,300.00	10,884,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,729,580.40	99,208,585.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,788,820.00	6,271,885.00
210604	Урсгал засвар	49,940,760.40	92,936,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,210,000.00	10,967,000.00
210702	Дотоод албан томилолт	1,210,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	10,967,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	169,253,883.00	297,732,887.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	140,534,863.00	269,718,487.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,900,000.00	9,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	341,400.00	497,500.00
210807	Газрын төлбөр	2,982,320.00	7,116,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,430,000.00	9,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,689,236.46	35,654,467.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	4,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	4,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,189,236.46	31,654,467.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,354,420.46	22,276,763.83
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	38,834,816.00	9,377,703.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	55,709,600.00	40,899,931.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	55,712,200.00	40,906,665.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,712,200.00	40,906,665.00
2200	Дотоод эх үүсвэрээр	55,712,200.00	40,906,665.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	55,712,200.00	40,906,665.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(55,712,200.00)	(40,906,665.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,600.00)	(6,734.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,334.00	6,734.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,734.00	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,285,020,112.91	12,782,788,168.47	(40,264,914.45)	16,027,543,366.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,285,020,112.91	12,782,788,168.47	(40,264,914.45)	16,027,543,366.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	1,097,358,200.00	697,069,030.71	-	1,794,427,230.71
Тайлант үеийн үр дүн	-	-	95,779,642.42	95,779,642.42
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,382,378,312.91	13,479,857,199.18	55,514,727.97	17,917,750,240.07
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,382,378,312.91	13,479,857,199.18	55,514,727.97	17,917,750,240.07
Тайлант үеийн үр дүн	-	-	139,088.01	139,088.01
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,382,378,312.91	13,479,857,199.18	55,653,815.98	17,917,889,328.08

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Б	1	2	3=1-2	4=2/1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	448,867,700.00	426,597,670.17	22,270,029.83	95.04
УРСГАЛ ЗАРДАЛ	448,867,700.00	426,597,670.17	22,270,029.83	95.04
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,867,700.00	425,597,670.17	22,270,029.83	95.03
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,280,200.00	200,757,922.69	8,522,277.31	95.93
Үндсэн цалин	158,053,400.00	152,136,610.69	5,916,789.31	96.26
Нэмэгдэл	35,350,800.00	34,338,312.00	1,012,488.00	97.14
Унаа хоолны хөнгөлөлт	15,876,000.00	14,283,000.00	1,593,000.00	89.97
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,160,100.00	26,160,100.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	17,788,800.00	17,788,800.00	-	100.00
Тэтгэмжийн даатгал	2,092,800.00	2,092,800.00	-	100.00
ҮОМШӨ-ний даатгал	1,674,300.00	1,674,300.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	418,600.00	418,600.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	4,185,600.00	4,185,600.00	-	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,731,200.00	38,599,002.38	10,132,197.62	79.21
Гэрэл, цахилгаан	24,046,000.00	20,431,475.00	3,614,525.00	84.97
Түлш, халаалт	21,772,000.00	16,863,421.56	4,908,578.44	77.45
Цэвэр, бохир ус	2,913,200.00	1,304,105.82	1,609,094.18	44.77
Хангамж, бараа материалын зардал	14,864,900.00	14,503,169.72	361,730.28	97.57
Бичиг хэрэг	2,830,500.00	1,800,000.00	1,030,500.00	63.59
Тээвэр, шатахуун	2,304,600.00	3,031,246.00	(726,646.00)	131.53
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,745,100.00	2,286,844.72	458,255.28	83.31
Ном, хэвлэл	620,000.00	1,026,400.00	(406,400.00)	165.55
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,564,700.00	2,699,080.00	(134,380.00)	105.24
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,800,000.00	3,659,599.00	140,401.00	96.31
Нормативт зардал	1,774,200.00	1,734,000.00	40,200.00	97.73
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,774,200.00	1,734,000.00	40,200.00	97.73
Эд хогшил, урсгал засварын зардал	12,047,300.00	11,455,700.00	591,600.00	95.09
Багаж, техник, хэрэгсэл	1,800,000.00	1,769,000.00	31,000.00	98.28
Урсгал засвар	10,247,300.00	9,686,700.00	560,600.00	94.53
Томилолт, зочны зардал	1,940,000.00	-	1,940,000.00	-
Дотоод албан томилолт	1,940,000.00	-	1,940,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,069,800.00	132,387,775.38	682,024.62	99.49

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,049,500.00	114,464,975.38	584,524.62	99.49
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	9,900,000.00	9,900,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	-	85,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	510,000.00	497,500.00	12,500.00	97.55
Газрын төлбөр	4,525,300.00	4,525,300.00	-	100.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	448,867,700.00	426,590,936.17	22,276,763.83	95.04
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	448,867,700.00	426,590,936.17	22,276,763.83	95.04
Улсын төсвөөс санхүүжих	448,867,700.00	426,590,936.17	22,276,763.83	95.04
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,734.00	(6,734.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	21	21	-	100.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	21	21	-	100.00
Удирдах ажилтан	1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	12	12	-	100.00
Үйлчлэх ажилтан	8	8	-	100.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	421,817,127.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	421,817,127.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	409,439,423.56
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	35,112,718.00
Үндсэн цалин	-	2,564,000.00
Урамшуулал	-	32,548,718.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	4,389,089.88
Тэтгэврийн даатгал	-	4,389,089.88
Хангамж, бараа материалын зардал	-	58,370,704.00
Бичиг хэрэг	-	5,739,800.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	300,000.00
Ном, хэвлэл	-	39,375,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	12,955,904.00
Нормативт зардал	-	9,150,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	9,150,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	126,104,800.00
Багаж, техник, хэрэгсэл	-	35,557,700.00
Тавилга	-	7,297,100.00
Урсгал засвар	-	83,250,000.00
Томилолт, зочны зардал	-	10,967,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	10,967,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	165,345,111.68
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	155,253,511.68
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	500,000.00
Газрын төлбөр	-	2,591,600.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	7,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	12,377,703.44
Бусад урсгал шилжүүлэг	-	12,377,703.44
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,000,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		9,377,703.44
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		421,817,127.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	421,817,127.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	40,342,021.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	10,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	371,475,106.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	421,817,127.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=- (I)-(II)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Богд хааны ордон музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код:
2020.02.18			САГ-2020/115/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Богд хааны ордон музей		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Нийт 3,134.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	3,134.9	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Ц.Эрдэнэбаатар Б.Эрдэнэчимэг
2	Хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон 37,500.0 мянган төгрөгөөс, 3,750.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаад, 4,754.9 мянган төгрөгийн НДШ тооцоогүй байна.	4,754.9	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Ц.Эрдэнэбаатар Б.Эрдэнэчимэг
Нийт		7,889.8			

